

Я.Бямбасүрэн, “Ядууралд нөлөөлж буюу хувь хүний хүчин зүйлс”, Удирдахуйн онол, практикийн асуудлууд № 9, 2011, хэвлэгдсэн ЯДУУРАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХУВЬ ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Доктор (Ph.D) Я.Бямбасүрэн

Хэдийгээр эртний сэтгэгчдээс /Аристотель/ эхлэн ядуурлын мөн чанар, түүнийг хэрхэн арилгах арга замыг авч үзэж олон онол сургааль гарч, өнөөгийн төрөөс чамгүй арга хэмжээ авч байгаа хэдий ч ядуурлыг нэн шийдвэрлэсэн улс орон хараахан бий болгоогүйн дээр дэлхий дээр (UNDP 1999) 1.3 тэрбум хүн өдөрт 1 ам доллараас бага орлоготой, мөн үүн дээр дахин 1 тэрбум хүн анхдагч хэрэгцээгээ хангаж чадахгүй байна. Манай орны хувьд ч энэ байдал хамгийн эмзэг асуудлын нэг хэвээр байж, нийтүн амын 36,1 (ҮСГ 2005) хувь нь амьжиргааны баталгаажих доод үвшингээс доогуур амьдралтай, цаашид энэ үзүүлэлт буурна гэсэн найдлага маш бага байна. Иймд ядуурлын мөн чанарыг ойлгох, үүнийг гэтлэн давахад дэмжих төрийн бодлогыг зөв оновчтой сонгон хэрэгжүүлэх асуудал чухал хэвээр байгаа бөгөөд цаашид ч чухал хэвээр байх нь тодорхой байна.

Томас Аквинский, Жон Локк нар ядуус туслах үүнээс гаргах арга замыг ёс зүй, өглөг буян үйлдэх үүднээс, Адам Смит болон Давид Рикардо нар эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор Мальтус болон түүний шавь нар хүн амын өсөлтийг эдийн засгийн болон боловсролын өсөлттэй хамаатуулан авч үзэж байжээ. Эхэн үедээ ядууст туслах, ядуурлаас гаргах арга замыг цум хийд буяны байгууллага анхааран ажиллаж байсан бөгөөд Англид 1597 онд ядуус туслах хууль гарснаар хамгийн анхны ядуурлын талаарх өрийн бодлого Европт эхэлжээ. Монгол улсын үүхийн сурвалж бичгийг үзвэл * 1248 онд тарианы гарц муудаж, мал ихээр хорогдсон тул ард иргэд өрийн сангаас тусламж олгож байсан бөгөөд 1264 онд Хубилай хааны зарлигаар ядуу дорой амьдралтай, өнчин, бэлэвсэн эмэгтэй зэрэг хүмүүст жил бүр улсын сангаас тэтгэмж олгохоор шийдвэрлэж байжээ. Энэ монголын хамгийн анхны ядуурлыг бууруулахаар хэрэгжүүлсэн төрийн бодлогын эхлэл болж байна.

20 дугаар зууны дунд үе хүртэлх ядуурлын тухай үзэл баримтлал, онол нь ядуусыг тэтгэн дэмжих, буян үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжиж ирсэн бөгөөд Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш ядуурал нь улс орон өрийн засгийн газрын анхаарлын төвд байж хөгжлийн бодлогын үндсэн асуудал болж байна. Энэ үеээс эхлэн ядуурлыг орлого болон хэрэглээний хомсдол болохын хувьд (Ланжуов 1997, Равиллион 1994, Роунтрий 1902), хүний анхдагч хэрэгцээ талаас (Исерман 1979, Хеншель Ланжуов 2000, Стриттон 1981, 1984), хүний хөгжилтэй холбоотойгоор (НҮБХХ 1997, Сен 1983), оролцоо нийгмийн ялгаварлалтай холбон (Таунсенд 1979, Дэлхийн банк, Де Хаан 1998, Сен 1997, Нараян 2000) тус тус судлан авч үзэж үүний дагуу бодлогын хувилбарыг санал болгон улс орнуудад тохиромжтойг хэрэгжүүлж байна. Улс орнуудад хэрэгжсэн ядуурлыг бууруулах бодлогын үр дүн янз бүр билээ. Тухайлбал, Тайвань, Өмнөд Солонгост

*Мянган жилийн харьцуулсан үхснэгт 1000 -2000, 1995, Ц.Дамдинсүрэн /Ц. Баярсайхан дахин хэвлүүлсэн/

хэрэгжсэн ядуурлыг бууруулах бодлого нь эдийн засгийн өсөлтийг хангах, боловсролыг дээшлүүлэх бодлоготой нягт уялдаатай байж амжилттай хэрэгжсэн байна. Харин Африк, Латин америкийн улс орнуудад хэрэгжсэн бодлого төдийлөн тогтвортой үр дүнд хүрээгүй байна (World Bank 2000/2001).

Ядуурлын байдалд оролцооны аргаар үнд шинжилгээ хийх судалгааны тайлангаас үзэхэд 2000-2005 оны хугацаанд дундаж орлоготой өрхөөс ядуучуудын эгнээнд шилжсэн өрхийн тоо дундаас дээшилсэн өрхийн тооноос ихээхэн илүү байна гэжээ. Нөгөөтэйгүүр ядуурлын үндсэн шинж тэмдэг үе үе илэрч байсан өрхүүд энэ хугацаанд ужиг ядууралд нэрвэгдсэн байна. Мөн судалгаанд оролцсон бүх бүлэг ядуурлын түвшин таваас зургаан жилд өдийлөн буур ахгүй нэмэгдэнэ гэсэн байна. Монгол банк, МУИС социологийн тэнхмийн хамтран хийсэн түүвэр судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчдын 78,5 хувь нь ядуурал өсөж байна хэмээн авч үзсэн бөгөөд энэ нь 2003 оны мөн адил судалгааны үзүүлэлтээс 11 хувиар илүү байна (Монгол банк 2005).

Ядуурлын асуудал үндсэндээ ядуурсан иргэн, төр хоёрын хамтын ажиллагааны үр дүнгээс хамааралтай. Өнөөдрийн байдлаар төрийн бодлого, түүний ядууралд нөлөөлөх хүчин зүйлийг олон янзаар судалсан боловч ядуу иргэнээс хамаарах зүйлийг бага судлагдсан байна гэж үзэж болохоор байна. Ядуурлын асуудал өөрийн нэн өргөн агаад түвэгтэй олон нугачаа зангилаатай учир энэ илтгэлийн хүрээнд ядууралд хүргэж байгаа хувь хүний хүчин зүйлийг зөвхөн авч үзэх болно.

Ядуурлын учир шалтгааныг Дэлхий банкнаас зохион байгуулсан ядуусыг сонсох, ядуурлыг тэднийг оролцооны тусламжтайгаар таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд дараах үзүүлэлтээр тодорхойлсон байна. Үүнд

- Анхдагч хэрэгцээгээ хангах жөрөнгө, орлогын хомсдол, тухайлбал хоол, хүнс орон байр, бололцооны боловсрол, эрүүл мэндийн түвшин
- Нийгмийн болон төрийн институцид хандах дуу хоолой, эрх мэдэл сульдах байдал
- Гэнэтийн гамшиг, нөхцөл байдлыг эмзэг, даван туулах чадваргүй байх (World Bank 2000/2001)

Мөн манай улсад 2005 онд АХБ, Дэлхий банк, ҮСГ хамтарсан ядуурлыг оролцооны аргаар үнэлэх судалгаа ядуурлын учир шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хөрөнгөө алдах, орлогын түвшин доошлох, гэр бүлийн гишүүд өвдөх нас барах, гал түймэрт өртөх зэрэг гэнэтийн аюулд нэрвэгдэх, залхуу байх итгэл алдрах, архичин болох зэрэг ядууралд орох үндсэн шалтгаан болж байна хэмээн үзжээ (ҮСГ, АХБ, ДБ 2006).

Манай орны хувьд ядууралд орж байгааг шалтгаанд залхуу байх, итгэл алдрах болон архичин болох гэсэн нэмэлт шалтгааны гаргаж ирсэн их сонирхол татаж байна. Мөн бусад учир шалтгаанууд нь шууд үнтэй холбоотой бус дам хамааралтай байна. Энэ дам хамааралтай шалтгаан, нөхцлийг төр, нийгмийн дэмжлэгээр гэтлэн давж болно. Бусад улс орнуудад хийгдсэн оролцооны судалгаанд үүнтэй ижил төстэй шалтгаан бараг ажиглагдахгүй байна. Энэ шалтгаан нь цэвэр хувьд хамаарсан учир шалтгаан

бөгөөд цөөнгүй тохиолдолд хялбархан залруулах боломжтой асуудал юм. Д. Аюурбунь, Ц. Болд (2005) нарын “Ядуурлын хам шинж” гүүрлэлд ядууралд хүргэж байгаа хүчин зүйлд бэлэнчлэх сэтгэлгээ, авилгал хээл хахууль, нийгмийн социал эрх зэрэгт нэнээс салах, боловсролгүй байх зэргийг авч үзжээ. Нөгөө талаас хэрэв уг хувь хүн залхуу, архичин эсвэл амьдралдаа итгэл алдарсан байвал ядуурлын бодлого хэрэгжээд түүнийг ядуурлаас гаргаж чадахгүй нь нэн тодорхой юм.


Түүнчлэн Х.Уртнасангийн (2001) хийсэн судалгаагаар “судалгаанд оролцсон арван хүн тутмын нэг нь ямар ч хөдөлмөр зарахгүйгээр үлгэрт гардаг шиг ид шидийн хүчээр амар хялбар амьдрахыг хүсэж” байгаа нь нотлогдсон байна. Мөн түүний хийсэн судалгаанд үнэнч шудрага байдлыг эвхэн тэтгэврийн хүмүүс илүүтэйд үзэж бусад салбарын ажил эрхлэгчид арваас доош хувьтайгаар нэлэж үзсэн байна. Нөгөө талаас сайн ажиллавал сайхан амьдарна гэсэн үзэл нэлэмж сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч харин эрх мэдэл танил талтай бол сайхан амьдарна гэсэн үнэлэмж дээшилсэн байна. Эдгээр тоо баримтууд нь манай үн амын дунд амар хялбар амьдрах, бусдаар тэтгүүлэх сэтгэлгээ нилээд түгээмэл шинжтэй байгааг харуулж байна. Энэ бусдаар тэтгүүлэх, ид шидийн хүчээр амар хялбар замаар сайхан амьдрах гэсэн үзэл санаа нь өнөөдрийн олон хадгаламж зээлийн хоршооны дампуурал, дундаж байдлаас ядуучуудын эгнээнд шилжиж байгаагийн нэгэн шалтгаан гэж үзэж болно.

Мөн амар хялбар амьдрах гэсэн үзэл санааны нөгөө тал нь өөрийгөө дайчлан ажиллахгүй, хөгжихгүй байх буюу залхуурлын үндэс болж байна. Түүнчлэн энэ байдал нь мэдлэг, мэдээллийн хоцрогдол, дасан зохицох, бэрхшээлийг гэтлэн давах чадварын хомсдол, эдийг зөв зарцуулах аргын доройтол зэргийг дагуулж эрсдэлд эмзэг байдлыг бий болгож улмаар итгэл алдран дорой байдалдаа автагдан ужиг ядууралд орохогчдийг бүрдүүлж байна. Мөн ядуурлыг аргаар судалсан тайланд ядуу иргэд ядуурлаас гархад өөртөө итгэлтэй, хатуужилтай хөдөлмөрч байх нь чухал хүчин зүйл гэж үзжээ. Булган, Дорнод, Увс болон Хэнтий аймагт ядуу иргэдтэй хийсэн ярилцлага судалгаанаас үзэхэд гадны нөлөөллөөс болж ядуурсан иргэд өөртөө итгэлтэй, хөдөлмөрч байснаараа ядуурлаас гаргасан байхад хувийн зүйлээс хамаарч ядуурсан иргэд ужиг ядууралтай байнгын дэмжлэг шаардсан байдалтай байна.

Дээрхи байдлаас дүгнэн үзвэл ядууралд хүргэж байгаа хувь хүний хамгийн гол хүчин зүйл нь бусдаас хамааралтай байх сэтгэлгээ/бэлэнчлэх/ буюу бусдаар тэтгүүлэх найдлага юм. Энэ бусдаар тэтгүүлэх найдлага зөвхөн залхуурлаас хамаарахгүй бөгөөд үүнийг өдөөгч, тэжээн тэтгэгч нь өнөөдрөөр баримжаалсан улс төрчийн үйлдэл, төрийн өрөвдөх болон найдлага төрүүлэх бодлого зэрэг (Я.Бямбасүрэн 2005) юм.

Үүнийг бусдаас хамааралт байдал үний нас хоёрын хамаарлыг авч үзвэл ерөнхий хамаарал нь урвуу болно. Энэ нь үн насжих тусмаа бусдаас хамаарах байдал багасаж харин тодорхой насны үвшинд хүрсэн үед эргээд хамаарах байдал нь өсөх байдалтай дэгээ хэлбэрийн хамааралт зүй тогтол ажиглагдаж байна.

Дүрслэл 1. Хамааралт байдал ба насны харьцаа



Хэрэв тухайн үний хөгжлийн тодорхой шатанд эволюцийн гажилт үүсвэл энэ хамааралт байдлын (ХБ) дүрслэл шулуун шугам болох тодорхой хэлбэр үрсээ өөрчлөх зэрэг үзэгдэл ажиглагдах болно. Тухайлбал тухайн хүн ямар 30 насандаа ямар нэгэн гэмтэл осолд орж бусдын тусламж дэмжлэгээр амьдрах аргагүй болсон гэж үзвэл тухайн график дараах байдлаар дүрслэгдэх болно. Игөө талаар төрөөс “найдлага төрүүлэх” болон “өрөвдөх” бодлого нь мөн иргэдийн бусдаас хамаарал багатай байх эрмэлзэлийг мохоож, бэлэнчлэх сэтгэлгээг хөгжүүлж хамаарлын шугамыг шулуун болгох болно.

Хувийн шинж чанараас хамааран ядууралд орж байгаа гэдэг хамааралт байдал (ХБ) буюу бэлэнчлэх сэтгэлгээ өндөр бараг тогтмол шулуун байна гэж ойлгож болно. Хүүхдийг нас насанд нь тохирсон шийдвэр гаргах эрх мэдэл олгох хэт бөөцийлөх нь ирээдүйн ядуу иргэний бэлтгэж байгаа асуудал юм. Нийгмийн харилцаанд гишүүдийг нас насандаа өөрийн хүсэл зоригоор шийдвэр гаргах хэм хэмжээ, боломжоор хангах нь хамааралт байдлыг бууруулахад дэмжлэг болох алхам юм.


Хувь хүний ядууралд хүргэж байгаа нэгэн гол нөхцөл болох орлого олох чадамжийг насны өсөлттэй хамааруулан авч үзвэл ерөнхийдөө шууд хамаарал ажиглагдах бөгөөд мөн тэтгэврийн насанд үрснээс хойш урвуу хамааралт байдал ажиглагдах болно. Хүн нас ахих тусмаамнө хуримтлагдсан мэдлэг, туршлага, нийгэмд эзлэх байр сууриараа давамгайлан орлого олох чадамж (ОЧ) өсөх бөгөөд энэ зарим нэг нас харгалзсан мэргэжлийн хувьд энд дүрслэн үзүүлснээс өөр байж болно. Үүнийг графикаар дүрсэлбэл буруу харсан дэгээ хэлбэрийн дүрс ажиглагдах болно.

Хувь хүн өөрийн орлого олох чадамжаа (ОЧ) ямар нэгэн байдлаар алдана гэдэг энэ функц катастрофт орох бөгөөд математикийн хэлээр бол тасралттай болно. Хүний орлогын чадамжийн функц тасралттай бол энэ ядууралд орох шалтгаан болж болох юм.

Харин одоо энэ хоёр графикийг нэгтгэн хамааралт байдал болон орлого олох чадамжийн харилцан хамаарлыг авч үзвэл харилцан урвуу хамаарал ажиглагдах бөгөөд хамааралт


байдал багасах тусам орлого олох чадамж нэмэгдэх бөгөөд нөгөө талаас орлого олох чадамж ихсэх тусам хамааралт байдал багасна гэсэн харилцаа бий болно. Хамааралт байдал болон орлого олох чадамж харилцан хамааралын үй тогтол нь графикийн хэлбэрийг тодорхойлох бөгөөд бусад нөхцлийн өөрчлөлт нь графикийн паралель шилжилтийг санал болгох болно.

Дүрслэл 2. Хамааралт байдал ба орлого олох чадамж (ОЧ)-ийн харилцан хамаарал



Энэ графикийг харвал хүмүүсийн бие даан орлого олох эрмэлзэл өсөөгүй, эсвэл тэдний орлого олох тэгш боломжоор хангагч үед эдийн засгийн өсөлт, боловсролын түвшний өсөлт нь хамааралт байдлыг бууруулахгүй учир ядуурлыг бууруулахгүй болохыг хялбархан харч болно. Аливаа хүмүүсийн сэтгэлгээ өөрчлөгдөөгүй, сэдэл санааг өөрчлөөгүй нөхцөлд эдийн засгийн өсөлт нь графикийг зөвхөн шилжүүлэх үйлдэл хийх бөгөөд энэ хөгжсөн оронд ч гэсэн харьцангуй ядуурал буурахгүй байгаагийн тайлбар юм.

Нөгөө талаас зөвхөн хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөх, боловсролыг дэмжих бодлого нь



мөн л графикийг шилжүүлэх бөгөөд хүмүүсийн бусдаас хамаарах байдал буурах боловч

орлого олох чадамж өссөхгүй орлогын ядуурал байсаар байх болно. Энэ хуучин социалист орнууд болон африкийн зарим оронд боловсролын шинэ харьцангуй дээшилсэн боловч өрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хөгжлийн хоцрогдолоос шалтгаалан ядуурал буурахгүй байгаагийн нэг тайлбар юм.

Хамааралт байдлыг зохистой үвшинд хүргэлгүйгээр ядуурлыг бууруулна гэдэг нь боломжгүй зүйл бөгөөд энэ нь дараахь сөрөг үр дагаврыг үүсгэгч хүчин зүйл болж байна. Үүнд:

- Өөртөө итгэлгүй болох, айдаст баригдах
- Бусдын хараат болох
- Таамаг мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах
- Нийгэм, орчин тойрондоо гомдоллох, буруутан этгээдэд өсөрхөх, түүнийг шийтгэх
- Гэр бүлийн уур амьсгалыг бусниулах
- Бусдын тусламжийг тасралтгүй хүсэж орлогын хомсдолд орох
- Хувь заяандаа найдах, мухар сүсэгт автах
- Баялаг бүтээхийн мөн чанарыг ойлгохгүй болох
- Нийгэмд сөрөг үзэгдлийг дэлгэрүүлэх /хулгай, дээрэм бусад нийгмийн эмх замбараагүй байдал/

Эдгээр үр дагавар нь нийгэмд байнгын ядуу давхаргыг төлөвшүүлэх, гэмт хэргийн сүлжээг бий болгох, нийгмийн хамгаалалтын зардлыг өсгөх зэрэг дагалдах үр дагавруудыг бий болгоно.

Хамааралт байдал болон насны хамаарал 0-оос тэтгэврийн нас хүртэл урвуу хамааралтай бөгөөд тэтгэврийн насаас эхлэн шууд хамааралтай болж байна. Орлого олох чадамж болон насны хамаарал 0 оос тэтгэврийн нас хүртэл шууд хамааралтай, тэтгэврийн насаас эхлэн урвуу хамааралтай байна. Энэ хоёр хамаарлаас насны үзүүлэлтээр тэнцүүлэн хамааралт байдал орлого олох чадамжийн хамаарлыг тодорхойлбол урвуу хамааралтай байна. Хамааралт байдал бага байх тусам орлого олох чадамж нэмэгдэж байна. Иймд ядуурлыг бууруулах бодлого нь хамааралт байдлыг багасгах сэдэл санааг дэмжихэд түлхүү чиглэх шаардлагатай гэж үзэж болно.

Хувь хүний ядууралд хүргэж байгаа гол хүчин зүйл болох хамааралт байдал буюу бэлэнчлэх сэтгэлгээг арилгахад хүмүүсийн сэдэл санаа өөрчлөх, улмаар өөрчлөгдсөн сэдэл санааг хөхиүлэн дэмжих, нийгэм, эдийн засгийн орчныг төлөвшүүлэх зэрэг цогц үйл ажиллагаа хэрэгтэй бөгөөд зөвхөн ядуурлыг хэмжих эсвэл хүний хөгжлийн тоо баримтыг тооцох төдийгөөр хязгаарлаж болохгүй юм.

Хэрэв хамааралт байдлыг багасгахад чиглэсэн бодлого хэрэгжихгүй бол боловсрол, эрүүл мэндэд хөрөнгө оруулаад эдийн засгийн өсөлт нэмэгдэвч ядуурал буурахгүйгээр

зогсохгүй, энэ нь нийгмийн хэв журмыг тогтоох, мөн бусад зардлыг өсгөх хор нөлөөтэй юм.

Эх сурвалж

1. Ц. Дамдинцэрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт 1000 -2000, 1995, /Ц. Баярсайхан дахин хэвлүүлсэн/
2. МОН01/99/01 өсөл, “Нийгмийн хамгааллын салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгөд хийсэн жендерийн дүн шинжилгээ”. “Жендерийн мэдрэмжтэй төсөв боловсруулах чадавхи бэхжүүлэх” УБ., 2004.
3. Монгол банк, МУИС-ын социологийн тэнхим, Монгол улсын нийгэм, эдийн засаг, банк санхүүгийн байгууллагын хөгжил, үйл ажиллагааны талаархи түүвэр судалгаа-2005, х-171-446, Монгол банк, Судалгааны ажил, 2005.
4. МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Социолого № 247, 2005
5. СЭЗЯ, Хөдөлмөр эрхлэлтийн салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгөнд хийсэн жендерийн дүн шинжилгээ /судалгааны тайлан/. УБ,2004.
6. Уртнасан Х. Монголын Нийгмийн өлөвшил: зан төлвийн өөрчлөлт, ШУА ФСЭХ, 2001
7. ҮСГ, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк Оролцооны аргаар ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх нь, 2006
8. ҮСГ, Дэлхийн Банк, МБ -ын Хөгжлийн хөтөлбөр, “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002 -2003 он”. УБ., 2004.
9. ҮСГ, Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл 1989-2002 он, УБ-2003
10. ҮСГ, Статистикийн эмхтгэл 2005 он, УБ-2005
11. ШУТИС-ийн КТМС-ийн судалгааны баг, Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд /судалгааны хураангуй/. УБ., 2004.
12. Amartya Sen and others, The Standart of Living, 1985, Cambridge University Press
13. Amartya Sen, Development as freedom, Oxford University Press, 1999
14. Deb Johnson, Insights on Poverty, Oxfam, 2002
15. Linda I. Reutter and etc, Lay understandings of the effects of poverty: a Canadian perspective, p-514-530, Health and social care in the community 13(6), 2005
16. Michael Lipton, Martin Ravallion, Poverty and Policy, p-2553-2638 in Handbook of development economics, Volume III, Edited by J. Behrman and T.N. Srinivasan, 1995, Elsevier Science
17. Stuart Rutherford, The poor and their money, Department of International Development, Oxford University press, 2000.
18. UNDP, “Overcoming Human Poverty”. Poverty Report 1998.
19. UNDP, “Overcoming Human Poverty”. Poverty Report 2000.
20. UNDP/SIDA, Study Report. Bringing Herders' Assets Into Full Economic and Productive Use. “Poverty Research and Employment Facilitation for Policy Development”, MON/01/U01 Project. 2004.
21. World Bank, World development report 2000/2001